

хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, ёс суртахуунтай, бүтээлч сэтгэлгээтэй иргэн, гэр бүлийн хөгжлийг дэмжсэн цогц бодлого хэрэгжүүлнэ.”

Боловсрол:

Зорилт: 2.1. Сургууль, цэцэрлэгийн сурах орчин, материаллаг баазыг бэхжүүлж, хамран сургалтыг нэмэгдүүлж, чанарыг сайжруулна.

2.1.1. 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулж, сургуулийн өмнөх боловсрол болон сургуулийн хамран сургалтыг нэмэгдүүлнэ.

2.1.2. Сургуулиудын бүтэц хэв шинжийг орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн оновчтой болгож, төрөлжсөн, гүнзгийрүүлсэн болон олон улсын хөтөлбөртэй сургуулийг хөгжүүлнэ.

2.1.3. Ерөнхий боловсролын сургалтын чанарын үнэлгээг жил бүр хийлгэж, улсын дунджаас дээгүүр үнэлгээтэй болно.

2.1.4. Монгол хэл, түүх, соёл зан заншил, өв уламжлал, эх оронч сэтгэлгээг сургалт хүмүүжлийн ажлын гол шалгууруудын нэг болгон бүх шатны боловсролын байгууллагад хэрэгжүүлнэ.

2.1.5. “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын мэргэжил сонголтод зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, хөгжлийн тэргүүлэх чиглэлийн мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудыг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулна.”

2.1.6. Багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.

2.1.7. Цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг хоёр дахин нэмэгдүүлж, “Үдийн хоол” үндэсний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлнэ.

2.1.8. Цэцэрлэг, сургуулийн болон сургалтын байгууллагын сурах орчныг бүх талаар сайжруулж, хөгжүүлнэ.

2.1.9. Сургууль, Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, их засварын ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

“Эрүүл мэнд”

Зорилт: 2.2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.

2.2.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд тогтмол хамруулах нөхцлийг бүрдүүлнэ.

2.2.2. Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, илрүүлэх арга хэмжээг сайжруулж өвчнийг буруулж, хязгаарлана.

2.2.3. Оношилгоо эмчилгээний дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэдэд орон нутагтаа оношлуулж, эмчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

2.2.4. Яаралтай тусламжийн чанар хүртээмжийг сайжруулж, парк шинэчлэлийг хийнэ.

2.2.5. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлэхэд онцгой анхаарч дэмжлэг үзүүлэн нийгмийн баталгааг сайжруулна.

2.2.6. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, хүртээмжид тавих хяналтыг сайжруулан эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.

2.2.7. Эмчилгээ, оношилгоо, сургалтад чиглэгдсэн алсын зайн анагаах ухааныг (теле медицин) өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний шатлал бүрт ашиглана.

2.2.8. Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөн, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.

2.2.9. Эрүүл мэндийн салбарт гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлж, даатгалын санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлнэ.

“Гэр бүл”

Зорилт: 2.3. Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт хүний хөгжлийг дэмжих Үндэсний бодлогын хүрээнд гарсан хууль эрх зүйн болон иргэдийн зөв санал санаачлагыг дэмжинэ.

2.3.1. Бодит судалгаанд суурилсан гэр бүлд ээлтэй төсөл хөтөлбөрийг дэмжинэ.

2.3.2. Хүүхдийн авъяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшлийг дэмжих эцэг эх, олон нийтийн байгууллага, аж ахуйн байгууллагуудын санаачлагыг дэмжинэ.

2.3.3. Залуу гэр бүлийн хөгжлийг дэмжсэн төсөл хөтөлбөрүүд боловсруулж, хэрэгжүүлнэ.

2.3.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхлэх боломж, нөхцлөөр хангана.

2.3.5. Хүүхдийн эрхийг хамгаалах аливаа хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт, хүнд хөдөлмөр эрхлэлтээс ангид байлгах үйл ажиллагааг дэмжих хувь хүн хуулийн этгээдтэй хамтран ажиллана.

2.3.6. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангана.

“Шинжлэх ухаан, технологи инноваци”

Зорилт: 2.4. Шинжлэх ухаан, инновацид суурилсан төсөл хөтөлбөрүүдийг дэмжинэ.

2.4.1. Шинжлэх ухаан, технологи, иновацийн хүний нөөцийг мэргэшүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.

2.4.2. Эрдэм шинжилгээний ажилтан, залуу судлаач эрдэмтдийн бүтээлийн үр шимийг үнэлдэг урамшууллыг бий болгоно.

2.4.3. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хаягдал, бохирдлыг бууруулсан, дахин ашиглалтыг бий болгосон, хүлэмжийн хийн ялгарал багатай, цэвэр технологи, инновацид суурилсан төслүүдийг бодлогоор дэмжиж, үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

“Хүнд ээлтэй амьдрах орчин”

Зорилт: 2.5. Эрүүл баталгаат орчин бий болгоно.

2.5.1. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж аюулгүй байдлыг хангана.

2.5.2. Орон сууц, гудамж талбай, ногоон байгууламжийн стандартыг хангуулна.

2.5.3. Агаар орчны бохирдлыг багасгаж, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлнэ.

2.5.4. Хот, суурин газрын үерийн далан, суваг, борооны ус зайлуулах шугам сүлжээний ажлыг сайжруулна.

2.5.5. Суурин газрын шөнийн гэрэлтүүлэг, гэрлэн дохио, камерын хяналтыг нэмэгдүүлнэ.

2.5.6. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд явган хүний болон дугуйн замын хэмжээг нэмэгдүүлнэ.

2.5.7. Хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин нөхцлийг сайжруулна

2.6. “Хөдөлмөрийн зах зээл

Зорилт: 2.6. Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санал санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх үндэсний зорилтыг хангаж ажиллана.

2.6.1. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулж, хяналтын механизмыг бий болгоно.

2.6.2. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг бүх талаар дэмжинэ.

2.6.3. Орон сууцны хангамжийг нэмэгдүүлж хямд үнэтэй орон сууц барих аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ.

2.6.4. Нийгмийн даатгалын шинэчлэлд иргэн бүр хамрагдах боломжийг бүрдүүлнэ.

2.6.5. Нийгмийн халамжийн үйлчилгээ зорилтот бүлэгт хүрч, ил тод нээлттэй чирэгдэлгүй болгоно.

2.6.6. Үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.6.7. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулна.

Гурав. “Амьдралын чанар ба дундаж давхарга”

Зорилго 3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэн дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.

Орлогод нийцсэн орон байр

Зорилт. 3.1.1. Дундаж орлоготой иргэдэд зориулсан өртөг багатай орон сууц барих аж ахуйг дэмжиж Жаргалант суманд 500-аас доошгүй айлын орон сууц бариулна.

3.1.2. Сумдын нэгдсэн дулааны шугам сүлжээг түшиглэн 12-24 айлын орон сууцыг барьж, ашиглалтад оруулна.

3.1.3. “Хашаандаа сайхан амьдарцгаая” хөтөлбөрийн хүрээнд Ховд хот, сумдын төвүүдэд хашаа, хороо, амины орон сууц, худаг, өрхийн аж ахуй хөгжүүлэх иргэдийн санал санаачилгыг дэмжиж, дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийж, айл өрхүүдийн амьжиргааны чанарыг сайжруулна.

3.1.4. “Хашаандаа сайхан амьдарцгаая” хөтөлбөрт 1000-аас доошгүй айл өрхийг хамруулна.

3.1.5. Хүн амын бүлгийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлнэ.

3.1.6. Ховд эко цементийн үйлдвэрийг ашиглалтад хүлээн авч орон сууцны үнэ ханшийг буулгаж бага өртөгтэй орон сууц, хувийн орон сууцаар хангана.

“Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес”

Зорилт 3.2. Залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай санхүүгийн болон бусад бүх төрлийн дэмжлэг үзүүлнэ.

3.2.1. Өрхийн болон жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжсэн “Үйлдвэрлэгч-Ховд” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

3.2.2. Залуучуудын гарааны бизнесийг дэмжинэ.

3.2.3. Малчид, газар тариалан эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх бизнесийн хоршоо, нөхөрлөлийг дэмжинэ.

3.2.4. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, чанар стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор иргэд, аж ахуйн нэгжүүдээ чадавхжуулж орлогыг нэмэгдүүлнэ.

3.2.5. Дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээг бэхжүүлэх Засгийн газрын бодлогын хэрэгжилтийг хангаж ажиллана.

“Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг”

Зорилт: 3.3. Биеийн тамир, спортын чанар хүртээмж үр дүнг сайжруулж, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.

3.3.1. Биеийн тамирын гадна талбайн тохижилт, стандартыг сайжруулж талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.3.2. Спортын заалны хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.3.3. Спортын сургалт, дасгалжуулалтын бааз суурийг өргөтгөж, спортын сургалттай дунд сургууль байгуулна.

3.3.4. Амжилт гаргасан тамирчид, багш дасгалжуулагчдыг урамшуулдаг хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.3.5. Хоол хүнсний болон эрүүл хооллолтын боловсрол олгох сургалтын бүхий л үйл ажиллагааг дэмжинэ.

“Газрын харилцаа”

Зорилт: 3.4. Газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх бодлогын хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.4.1. Хаягжилтын нэгдсэн системийг орон нутгийн хэмжээнд бүрэн хийнэ.

3.4.2. Газар ашиглалт нөхөн сэргээлтийн хяналттай механизмыг сайжруулна.

3.4.3. Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлэх Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлнэ.

3.4.4. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, орон зайн төлөвлөлтийг хийнэ.

Дөрөв. “Эдийн засаг”, эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд

Зорилго 4. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг тэтгэсэн эдийн засгийн суурийг бүрдүүлнэ.

Зорилт 4.1.1. Аймгийн Эдийн засгийг жил бүр тогтвортой өсгөх бодлогыг хэрэгжүүлнэ.

4.1.2. Төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын шууд хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчныг бүрдүүлнэ.

4.1.3. Төрийн худалдан авалтаар орон нутгийн үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжинэ.

4.1.4. Эрдэнэбүрэнгийн Шижигтийн хавцалд баригдах 90 мегаваттын Усан цахилгаан станцын төслийг хэрэгжүүлэхэд орон нутгаас бүх талын дэмжлэг үзүүлж, ашиглалтанд хүлээн авна.

4.1.5. Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэл, технологийн паркыг ашиглалтанд оруулж хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалт хийж, экспортод гаргана.

4.1.6. Цементийн үйлдвэрийг ашиглалтад оруулж, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж орон сууц, барилгын м²-ын үнийг бууруулна.

4.1.7. Хөшөөтийн нүүрсний уурхайг түшиглэсэн сайжруулсан утаагүй шахмал түлшний үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлнэ.

4.1.8. Газар тариалангийн бааз суурийг өргөтгөж тэжээлийн ургамал, овъёос, хөх тариа, жимс, жимсгэнэ, нарийн ногооны тариалалтыг 3000 га-гаар нэмэгдүүлнэ.

4.1.9. Дулааны станцын хүчин чадлыг нэмэгдүүлж, дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, байгууламжийг өргөтгөж, шинэчлэх ажлыг жил бүр хийж сайжруулна.

4.1.10. Газрын тос боловсруулах бага оврын үйлдвэр байгуулна.

4.1.11. Аялал жуулчлалын салбарын бүхий л чиглэлийг, соёлын биет бус өвтэй хослуулан өрсөлдөх чадвараа нэмэгдүүлнэ.

4.1.12. Чандмань, Цэцэг, Эрдэнэбүрэн, Ховд сумдыг нутгийн зам хөтөлбөрийн хүрээнд хатуу хучилттай замаар босоо, хэвтээ чиглэлийн замтай холбоно. Ховд-Улаангом чиглэлийг 165 км хатуу хучилттай авто замаар холбох төслийг дэмжинэ.

4.1.13. Нисэх буудлыг 4С ангиллын олон улсын нисэх буудал болгон хөгжүүлнэ.

4.1.14. Булган, Байтаг боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, тоног төхөөрөмжийг шинэчлэн, үйлчилгээний шуурхай байдал, чанарыг сайжруулна.

4.1.15. Босоо хэвтээ тэнхлэгийн авто замыг түшиглэн тээвэр логистикийн төв байгуулна

4.1.16. Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, баруун бүсийн барилгын материалын нэгдсэн лабораторийг байгуулна.

4.1.17. Сумдын албан байгууллагуудыг ариутгах татуургын нэдсэн системд холбоно.

Санхүү, төсвийн зохицуулалт

Зорилго 4.2. Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ.

Зорилт 4.2.1. Орон нутагт санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжиж санхүүгийн түрээсийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.2.2. Иргэн, хуулийн этгээд хөрөнгийн биржийн арилжаанд сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурласан, цахим арилжааны дэд бүтцээр шууд оролцох боломжийг орон нутагт бүрдүүлнэ.

4.2.3. Орон нутгийн татварыг боловсронгуй болгож татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын суурийг нэмэгдүүлнэ.

4.2.4. Төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцлийг бүрдүүлж шилэн болгоно.

4.2.5. Орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг санхүү, татварын бодлогоор дэмжиж, бүсийн нэмэгдэл олгоно.

4.3. Уул уурхай

4.3.1. Хөшөөтийн орд газрыг түшиглэн байгальд ээлтэй, дэвшилтэт технологид суурилсан “Нүүрс угаах үйлдвэр”-ийг байгуулна.

4.3.2. Уул уурхайн үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлж, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг хөгжүүлж, нөхөн сэргээлт, биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалалтыг сайжруулан хуримтлагдах нөлөөллийг бууруулна.

4.3.3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, судалгааны ажлыг дэмжиж, хайгуулын болон ашиглалтын лицензүүдэд хяналт, үнэлгээ хийж, хуулийн хэрэгжилтийг хангана.

“Бүс нутгийн хамтын ажиллагаа, Бренд бүтээгдэхүүн бий болгох”

Зорилт 4.4. Хөрш зэргэлдээ улс, аймаг, хотуудын хамтын ажиллагаа, худалдаа, үйлчилгээг өргөтгөж, бараа бүтээгдэхүүний эргэлтийг нэмэгдүүлнэ.

4.4.1. Хөрш аймаг, хотууд болон БНХАУ-ын Шинжань Уйгарын Өөртөө Засах Орон, ОХУ-ын Алтайн хязгаар, Тува, Казакстан улсын хот, мужуудтай чөлөөт худалдаа, аялал жуулчлал, соёлын харилцаа хамтын ажиллагаагаа өргөжүүлнэ.

4.4.2. Ховд хоттой 1000 км радиусаар холбогдсон 4 улсын 20 гаруй хот суурин газарт аймгийнхаа бараа бүтээгдэхүүн, түүхий эдээ сурталчлан экспортыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

4.4.3. Орон нутгийн онцлог брэнд бүтээгдэхүүн бий болгож буй иргэд, аж ахуйн нэгжийг дэмжиж, урамшуулна.

4.4.4. Шинэ санаа инновацид суурилсан оюуны бүтээл, шинэ бренд бүтээгдэхүүнд урамшил олгох системийг бий болгоно.

Хөдөө аж ахуй

Зорилго 4.5. “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалтын бүтээмжийг тооноос чанарт шилжүүлэх, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлэхэд чиглэсэн Шинэ хөдөө цогц төсөл боловсруулж, хэрэгжүүлнэ.”

Зорилт 4.5.1. Малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж, малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлнэ.

4.5.2. Халдварт өвчинтэй тэмцэх, мал сүргийг бүрэн вакцинжуулах дунд хугацааны стратегийг хэрэгжүүлж, гоц халдварт өвчингүй, тайван бүсийг баталгаажуулна.

4.5.3. Сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй үйлдвэрлэл эрхэлж орон нутгийн сүүний хэрэгцээг нэмэгдүүлж буй иргэн аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлнэ.

4.5.4. Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир, ноос, ноолуур, түүхий эд бэлтгэн тушаасан малчин, мал бүхий этгээдэд түүхий эдийн чанартай нь уялдуулан мөнгөн урамшуулал олгох тогтолцоог өргөжүүлнэ.

4.5.5. Хүлэмж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногооны дотоодын хэрэгцээг жилийн турш тогтвортой хангана.

4.5.6. Таримлын сэлгээ, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

4.5.7. Газар тариалангийн бүс нутагт усжуулалтыг нэмэгдүүлж, үрийн шилмэл сортын нөөц бүрдүүлэх, нутагшуулах ажлыг хийнэ.

4.5.8. Залуу малчин, тариаланч дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, өвөлжөө, хаваржаандаа орон сууц барихад дэмжлэг үзүүлнэ.

4.5.9. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ.

4.5.10. “Ховд Агро парк” төсөл хэрэгжүүлж, чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэд аж ахуйн нэгжүүдэд бүх талын дэмжлэг үзүүлнэ.

ТАВ. ЗАСАГЛАЛ

Зорилго 5. Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг тогтвортой засаглал, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд шилжих хүрээнд “Хариуцлагатай тунгалаг төр” хөтөлбөрийг үргэлжлүүлж, соёлтой төрийн

үйлчилгээтэй, авлига хүнд сурталгүй, төрийн үйлчилгээний ажлаараа тэргүүний аймаг болно.

Ухаалаг засаглал ба бүтэц

Зорилт 5.1. Тогтвортой, оновчтой, хариуцлагатай, хяналттай засаглалыг төлөвшүүлж, авлига хүнд сурталгүй аймаг болно.

5.1.1. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын ажил үүргийн давхцалыг арилгаж, чиг үүргийг оновчтой болгож, үйл ажиллагаа тогтвортой, оновчтой, залгамж чанартай, хяналттай, үр дүнтэй хэрэгжих нөхцөл бүрдүүлнэ.

5.1.2. Эдийн засаг, нийгэм, бизнес, засаглалын бүх шатанд олон талт түншлэлийг оновчтой, үр дүнтэй нэвтрүүлнэ.

5.1.3. “Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын ажилтан, сонгуультныг чадавхжуулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх дэд хөтөлбөр” хэрэгжүүлнэ.

Цахим Ховд

Зорилт 5.2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.

5.2.1. Хүн амыг өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбож, төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэн иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөл бүрдүүлнэ.

5.2.2. Цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтэц байгуулна.

Чадварлаг, ёс зүй, хариуцлагатай төрийн алба

Зорилт 5.3. “Хариуцлагатай тунгалаг төр” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүн, үр нөлөөг дээшлүүлж, соёлтой төрийн үйлчилгээтэй аймаг болно.

5.3.1. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудад чадахуйн зарчмыг хэрэгжүүлж, ёс зүй, сахилга хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгож, мэргэшсэн төрийн албыг бэхжүүлнэ.

5.3.2. Орон нутгийн төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийг чадавхжуулах сургалтын төв байгуулж, төрийн албан хаагчдын тасралтгүй сурч, хөгжих орчин бүрдүүлнэ.

5.3.3. Иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэж, төрийн үйлчилгээний соёл хүртээмж, хурд чанарыг дээшлүүлнэ.

5.3.4. Төр хувийн хэвшил төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг өргөжүүлж хамтын нээлттэй үйл ажиллагааг сайжруулна.

5.3.5. Төрийн болон иргэний нийгэм, төрийн бус байгууллага, бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагааг бүх талаар дэмжиж, нээлттэй болгоно.

5.3.6. Аймаг орон нутгийнхаа хөгжлийн зорилтыг хангахын тулд “Стандарттай Ховд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Хүний эрхийг дээдэлсэн Авлигагүй засаглал

Зорилт 5.4. Хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт түншлэлийг хөгжүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, тогтоомжуудын хэрэгжилтийг хангасан, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлнэ.

5.4.1. Бүх нийтэд хүний эрх, жендерийн боловсрол олгох, тэгш байдлыг хангах бодлого баримтална.

5.4.2. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлж, улс төр, нийгмийн амьдралын бүх хүрээнд эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг дэмжинэ.

5.4.3. Төрийн бүхий л байгууллагуудад ил тод байдлыг хангаж, шилэн дансны хуулийг бүрэн хэрэгжүүлнэ.

5.4.4. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчинг сайжруулах Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлнэ.

5.4.5. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, сургалтыг тогтмол зохион байгуулж, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлнэ.

Зургаа: “Ногоон хөгжил, баялаг ус”

Зорилт 6. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

6.1. Ховд аймгийн Ногоон хөгжлийн /2016-2026он/ хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж ногоон хөгжлийн загвар аймаг болно.

6.2. Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.

6.3. Байгаль орчны аюулгүй байдал эко боловсрол олгох үйл ажиллагааг шинэ шатанд гаргах байгаль орчны чиглэлийн Олон улсын болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжинэ.

6.4. Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай цэвэр технологи нэвтрүүлэн, уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицох чадавхыг бүрдүүлнэ.

6.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлнэ.

6.6. Хөрсний үржил шим чийгийг хамгаалж газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх, нөхөн сэргээх ажлыг бүх сумдын түвшинд хийнэ.

6.7. Нэн ховор, ховор амьтан, ургамлын нөөц ховордсон зүйлийг хууль эрх зүйн орчинд хамгаалах ажлыг нутгийн иргэдийн оролцоонд тулгуурлана.

6.8. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомсдлыг бууруулна.

6.9. Ховд хотод хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулна.

6.10. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг сайжруулж, бүс нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих төслийг олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

Долоо. “Амар тайван аюулгүй нийгэм, Дархан хил”

Зорилт: 7. Батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар аюулгүй байдлыг хангана.

7.1. Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээг тогтмол явуулна.

7.2. Цэргийн бүртгэл, цэрэг татлагыг чанартай явуулж бэлтгэл үүрэгтнүүдийн сургалтыг хуульд заасан үечлэлээр зохион байгуулах, сургалтад бэлтгэл үүрэгтнүүд болон албан тушаалтнуудыг хамруулна.

7.3. Улсын болон Цэргийн дайчилгааны командууд болон орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгж, орон нутгийн цэргийн отряд, сумангийн бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдлыг хангах, тэднийг сургалтад хамруулах, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, даалгавар бүхий сумууд, Зэвсэгт хүчний анги, салбартай тогтоосон хугацаанд тодотгол явуулна.

7.4. Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэх, боловсролын түвшинг дээшлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

7.5. Ховд аймагт үйл ажиллагаа явуулж буй Зэвсэгт хүчний анги, салбарын үйл ажиллагаа, алба хаагчдын ажиллах ая тухтай нөхцлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана.

7.6. Улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагааг чадавхжуулах орчин үеийн техник хэрэгслээр хангах бодлогыг дэмжинэ.

7.7. Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлнэ.

7.8. Архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, олон талт арга хэмжээг тогтмол зохион байгуулна.

7.9. Хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудыг материаллаг баазыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

7.10. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сургалт, мэдээллийг арга хэмжээг тогтмол зохион байгуулна.

7.11. Мал хулгайлах гэмт хэргийн гаралтыг бууруулна.

Найм: “Хот, сумын хөгжил”

Зорилго: Хүн амьдрахад таатай, хот, сууринг хөгжүүлж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлэн, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Зорилт 8.1. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангаж, хариуцлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгоно:

8.1.1. Ховд хотын агаарын бохирдол, утааг үе шаттайгаар бууруулна.

8.1.2. Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийж, бохирдол бага ялгаруулах, хог хаягдалгүй хэрэглээг дэмжих тогтолцоотой болгоно.

8.1.3. Ногоон барилгын стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгоно.

8.1.4. Авто зам, явган хүний болон унадаг дугуйн замын уртыг нэмэгдүүлж, иргэдэд ая тухтай зорчих боломжийг бүрдүүлнэ.

8.1.5. Тусгай хэрэгцээтэй иргэдийн зорчих зам, үйлчилгээний стандартыг бий болгож, мөрдүүлнэ.

Зорилт 8.2. Хот суурин газрын дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ухаалаг технологийн шинэчлэл хийнэ.

8.2.1. Хотын дахин төлөвлөлт, хэсэгчилсэн төлөвлөлтийг хийж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.

8.2.2. Инженерийн дэд бүтэц /Усан хангамж, дулаан, цэвэр, бохир, цахилгаан/-ийн хүчин чадлыг нэмэгдүүлж, орчин үеийн технологийг нэвтрүүлнэ.

8.2.3. Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийг нэмэгдүүлж, автобусны зогсоолыг сайжруулна.

Зорилт 8.3. Аймаг, сумын төвийг Бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамруулж сумдад “Сумын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

8.3.1. “Аймаг, сумын төвийг бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т сумдыг хамруулна.

8.3.2. Сумдын сургууль, цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн үйл ажиллагаа, материаллаг баазыг сайжруулах, хүний нөөцийг чадавхжуулах төсөл хэрэгжүүлнэ.

8.3.3. Сум, орон нутагтаа бизнес эрхлэх иргэн, аж ахуй, хоршоо, нөхөрлөлийг дэмжинэ.

8.3.4. Сумдын Мал эмнэлгүүдийг чадавхжуулах, материаллаг баазыг нь бэхжүүлэхэд онцгой анхаарч, малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.

8.3.5. Малын гаралтай түүхий эд, дайвар бүтээгдхүүнийг бэлтгэн нийлүүлэх тогтолцоог бий болгон хөгжүүлнэ.

8.3.6. Бэлчээрийг усжуулах, худагжуулах, хортон шавьж устгах ажлыг үргэлжлүүлэн бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ.

8.3.7. Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөрт зарим сумдыг хамруулна.

Зорилт 8.4. Тэжээлийн ургамал тарих, тахиа, гахайны аж ахуй, жимс, жимсгэнэ, хүлэмжийн аж ахуй эрхлэх иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн бодит дэмжлэг үзүүлнэ.

Зорилт 8.5. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр эрхлэх иргэн, аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ.

Аялал жуулчлал

Зорилт 8.6. Үзэсгэлэнт байгаль, олон үндэстэн, ястны биет болон биет бус соёлын өвийг түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

8.6.1. “Гурван сэнхэр төвтэй 5 од” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

8.6.2. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, Баруун бүсийн аялал жуулчлалын төв болно.

8.6.5. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж байгаа санал санаачлагыг төсөв, хөрөнгө оруулалтаар бодлогоор дэмжинэ. Аялал жуулчлал эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж олсон орлого, ашгаасаа нутгийн иргэд болон тухайн үйл ажиллагаа явуулж буй газрынхаа байгаль орчныг хамгаалах үйлсэд хувь нэмэр оруулж буй тохиолдолд бүх талаар урамшуулан дэмжинэ.

---oOo---



Аймгийн ИТХ-ын 2020 оны
2 дугаар хуралдааныг тогтоолын
1 дүгээр хавсралт

**“ХОВД АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН**

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин (2025 он)	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
Соёл							
1	Шинэ уран бүтээлийн тоо	тоо	30	50	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөгжимт драмын театр
2	Номын сангийн нийт сан хөмрөгт цахим сан хөмрөгийн эзлэх хувь	Хувь	1.5	5	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Нийтийн номын сан, сумдын номын сан
3	1000 хүн тутамд ноогдох соёл, урлагийн байгууллагын суудлын тоо	тоо	2700	3500	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөгжимт драмын театр, Сумдын соёлын төв
4	Соёл урлагийн үйлчилгээний хүртээмж	Тоо	323000	395000	Соёл урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоон өсөлт	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Соёл урлагийн газар
5	Төрийн өмчийн музейн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо	Тоо	6920	7500	үйлчлүүлэгчдийн тоон өсөлтөөр	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Аймгийн Музей
6	Урлагийн	хувь	12	13	Өсөлтөөр	Жилд нэг	Аймгийн Засаг даргын

	байгууллагаар үйлчлүүлэгчдэд хүүхдийн эзлэх хувь					удаа	Тамгын газар, Соёл урлагийн газар
Боловсрол							
7	Хамран сургалт	Хувь	ЕБС-75.3 СӨБ-95.1	ЕБС-80 СӨБ-96.5	Өсөлтийн хувиар	Жилд нэг удаа	Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, Аймгийн Боловсрол, соёл урлагийн газар
8	СӨБ-ын хамран сургалтын цэвэр жин	Хувь	75.3	80	Өсөлтийн хувиар	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар
9	5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсрол хамрагдалт	Хувь	89	98	Өсөлтийн хувиар	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар
10	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин.	Хувь	95.1	96.5	Өсөлтийн хувиар	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар
11	Цэцэрлэгийн бүлгийн багшид ногдох хүүхдийн тоо	Тоо	30	25	Хүүхдийн тоо бууралтаар	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар
12	Бага ангийн багшид ногдох хүүхдийн тоо	Тоо	29.9	28	Хүүхдийн тоо бууралтаар	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар
13	Бүлэг дүүргэлт /боловсролын бүх түвшнээр/	Тоо	СӨБ-30,7 ЕБС-27,4 Аймгийн төв- 30,2 Хөдөө-25,4	СӨБ-26,0 ЕБС-26,0 Аймгийн төв- 27,0 Хөдөө-25,0	Хүүхдийн тоо бууралтаар	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар
14	Дотуур байрны хангалт	Тоо	2105	2160	Дотуур байранд амьдрах хүүхдийн	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар,

					тоо, өсөлт		Боловсрол, соёл урлагийн газар
15	Хэрэгжүүлж буй дэд хөтөлбөр	Тоо	3	4	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар
16	Шинээр баригдах сургууль, цэцэрлэг, спорт заал, дотуур байр	Тоо	5	13	Хөрөнгө оруулалтын өсөлт	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар
17	Өргөтгөл баригдах сургууль цэцэрлэгийн тоо	Тоо	3	4	Өргөтгөлийн тоо 1-ээр нэмэгдэнэ	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар
18	Их засвар хийгдэх сургууль цэцэрлэг	Тоо	6	20	Хөрөнгө оруулалтын өсөлт	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар
Инноваци							
19	Инновацид суурилсан төсөл, хөтөлбөр, эрдэм шинжилгээний судалгаа	Тоо	13	20	Судалгаа шинжилгээний тоо өсөлт	Жилд нэг удаа	Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, Ховд их сургууль, Хувийн хэвшил
Эрүүл мэнд							
20	Хүн амын дундаж наслалт	Тоо	72.8	73.5	Төрөлтөөс тооцсон наслалтын өсөлт	Хоёр жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Аймгийн статистикийн хэлтэс
21	Дархлаажуулалтанд хамрагдсан хүүхэд	Хувь	98.8	99.6	Дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн өсөлт	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар
22	Халдварт бус өвчний эрт илрүүлэлт	Хувь	53.2	74.5	Халдварт бус өвчний илрүүлэлтийн өсөлт	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар

23	Оношилгоо эмчилгээнд шинэ технологи, ажилбар нэвтрүүлсэн байдал	Тоо	3	6	Шинээр нэвтрүүлсэн шинэ технологи, ажилбарын өсөлт	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, БОЭТ-ийн статистикийн алба
24	Шинээр олгосон яаралтай тусламжийн машин	Тоо	8	10	Өсөлтөөр	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар
25	Салбарын хүний нөөцийг чадавхижуулах хөтөлбөр	Тоо	1	2	Батлуулж хэрэгжүүлсэн хөтөлбөрийн тоо	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар
26	Эмнэлгүүдэд хэрэглэх эмийг тендерээр хангасан байдал	Хувь	73	80	Тендерээр хангасан эмийн өсөлт	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар
27	1000 амьд төрөлтөнд ноогдох нялхсын эндэгдлийн түвшин	Промил	18.0	12.0	Нялхсын эндэгдлийн бууралт	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар
28	100 000 амьд төрөлтөнд ноогдох эхийн эндэгдлийн түвшин	Продецимил	109.5	30.0	Эхийн эндэгдлийн бууралт	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар
29	Алсын зайн оношилгоонд шинээр холбогдсон эмнэлэг	Тоо	3	7	Зайн оношилгоо, үйлчилгээнд хамрагдсан эмнэлгийн өсөлт	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар
30	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хэмжээ	Хувь	69.4	85.5	Даатгалын хамралтын өсөлт	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн даатгалын тасаг
31	Шинээр барьсан, өргөтгөсөн, засварласан барилга	Тоо	6	14	Шинэчилж сайжруулсан барилгын өсөлт	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар
Гэр бүл							
32	Хүн амын өсөлт хэмжээ	Хувь	0.2	0.4	Өсөлтийн хэмжээ	Жилд нэг удаа	Аймаг, сумдын Засаг